



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 431

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Амны хөндийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх ажлын удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт-тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д үүрэг болгосугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081524

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 10 сарын 28 өдрийн
431 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



Ажлын удирдамж

Зорилго:

2006-2015 онд хэрэгжүүлэх “Амны хөндийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээ хийж, санал зөвлөмж боловсруулахад оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

- Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэнэ.
- Дунд хугацааны үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг тооцно.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг, оролцоонд дүгнэлт хийнэ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилтыг тооцно.
- Шалгуур үзүүлэлтийн биелэлт, хүрсэн түвшинг тооцон шалтгаан, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгнө.
- Хөтөлбөрийн зорилт тус бүрээр ололт амжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон үр дүнг тооцож, шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх арга замыг тусгасан тодорхой зөвлөмжүүд дэвшүүлнэ.
- Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсэх талаар үндэслэл бүхий санал дэвшүүлнэ.
- Үнэлгээний тайланг эцэслэн ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- Үнэлгээний дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.


Хугацаа:

2015 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 11 дүгээр сарын 26-ны өдрийг дуустал

Хүрэх үр дүн:

- Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, санал зөвлөмж дэвшүүлсэн байна.
- Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсэх асуудлыг Удирдлагын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн байна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 10 сарын 28 өдрийн
43.1 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ахлагч: Э.Оюунсүрэн, Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Гишүүд:
- Б.Хонгорзул, Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
 - Д.Ганзориг, Эрүүл мэнд, спортын яамны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
 - Ж.Энхзул, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийг дэмжих төвийн дарга
 - Д.Уранчимэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны дарга
 - Б.Оюунцэцэг, Эрүүл мэнд, спортын яамны Нүүр ам судлалын ерөнхий мэргэжилтэн